

Иргэний хамгаалалт ба үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх


Пүрэвийн Дамдин

Доктор (Ph. D), дэд профессор, pdamdin43@gmail.com

Оршил

Монгол Улсад “иргэний хамгаалалт” нэртэй шинэ алба 1960-аад оны дунд үед үүссэн. Тэгэхдээ тус алба гэнэт бий болоогүй, 1930 оноос эх сууриа тавьж 30 гаруй жилийн дараа үүсэж, дөчөөд жил түрүү үеийн уламжлалт аюул заналын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулсан түүхтэй юм. Судалгаанаас үзвэл 1930-1963 оныг иргэний хамгаалалтын алба үүсэхийн өмнөх буюу урьдчилсан нөхцөл бүрдсэн, 1964-1990 оныг хүйтэн дайны онцлогтой, 1990-2004 оныг шилжилтийн шинжтэй, харин 2004 оноос хойш үеийг тайван цагтай гэж гэж ангилах бүрэн үндэслэлтэй юм.

Зураг 1. Монгол Улсын иргэний хамгаалалтын албаны үүсэл, хөгжлийн үечлэл



Улсын хүн ам, онц чухал объектыг дайсны агаарын довтолгоо, химийн зэвсгийн аюулаас хамгаалах аргад 1930-1960-аад онд сургаж бэлтгэх, дайснаас хэрэглэж болох зэвсгийн хор хөнөөлийн талаар ард түмэнд сурталчлан ойлгуулах ажлыг Бүх цэргийн зөвлөлийн дэргэдэх Улсыг хамгаалах зөвлөл, Улсыг хамгаалах комисс, олон нийтийн байгууллагуудаас Монгол Улсыг хамгаалах явдалд туслах эвлэл (МУХЯТЭ), Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд (АӨХСДМО), Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг (АЦТСДН), Батлан хамгаалах хөдөлмөр нийгэмлэг (БХХН) зэрэг олон нийтийн сайн дурын байгууллага хариуцаж байсан хэдий ч үр дүн нь тогтолцоот арга хэмжээ болж төлөвшөөгүй байжээ.

Нэг. Монгол Улсын гадаад байдал ба эх орноо хамгаалахад ард иргэд, байгууллагуудын үүрэг, оролцооны эхлэл тавигдсан нь

Япон Манжуурт цэргийн хүчийг 1930-аад оны эхний жилүүдэд ихээхэн төвлөрүүлж, Хятадын зүүн хойд хэсэг, Өвөр Монголын олон аймгийг эзлэн авч, тэр нутаг дэвсгэрээ БНМАУ, ЗСБНХУ-ын эсрэг түрэмгий дайн явуулах бааз болгосон байв. Энэ нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл байдлыг үүсгэсэн бөгөөд эх орноо хамгаалах бололцоот арга хэмжээнүүд авах зайлшгүй шаардлагыг бий болгосон байв. Энэ цаг үед дайн, байлдаанаас хамгаалахад түүхэнд урьд нь байгаагүй хоёр том хүчин зүйлийг тооцох зайлшгүй шаардлага тулгарчээ. Эдгээр нь:

- Дэлхийн I дайнд 1915 онд Германы тал химийн хорт бодисыг анх удаа их хэмжээгээр хэрэглэж, эсрэг талынхаа цэргийг богино хугацаанд үй олноор нь устгаж, урьд нь байгаагүй их хохирол учруулсан сургамжаас улс орнууд суралцаж, химийн зэвсгээс хамгаалахад анхаарах болсон.
- Байлдаанд нисэх онгоц өргөн хэрэглэх болсон нь дайтагч улс орнуудын цэргийн байлдааны ажиллагаа зөвхөн фронтын шугам орчмоор хязгаарлагдах бус улс орны гүнд цохилт өгч, ар талд хохирол учруулах аюултай болсон явдал юм.

Ийм нөхцөл байдалд БНМАУ-ын Ардын засгийн газар, МАХН-ын Төв Хороо улс орноо харийн түрэмгийллээс сэрэмжлэн хамгаалахын тулд урьд нь тавигдаж байгаагүй шинэ зорилтыг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Энэ нь дайсантай галын шугамд байлдааны ажиллагаа явуулахын зэрэгцээ улсын гүнд хот, суурин газрын хүн ам, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагыг дайсны агаарын довтолгоо, химийн зэвсгийн хөнөөлөөс хамгаалах шаардлага үүссэнтэй холбоотой байлаа. Ингээд МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид, Хянан байцаах төв комиссын гишүүдийн 1929 оны долоодугаар сарын 22-ны өдрийн 40 дүгээр хурлаас Улсыг батлан хамгаалах зөвлөлийг (УБХЗ) Бүх цэргийн зөвлөлийн дэргэд байгуулав.

БНМАУ-ын Засгийн газрын 1930 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 40 дүгээр хурлын тогтоолоор УБХЗ-ийн харьяанд Монгол Улсыг хамгаалах явдалд туслах сайн дурын эвлэл (МУХЯТЭ) байгуулж, дүрмийг нь хэлэлцэж, баталсан байна. Тус эвлэлийг энэхүү дүрэмд “Олон ардуудаас сайн дураар байгуулсан газар” гэж тодорхойлоод дүрмийн 3.6-д “Агаарын ба хорт зайн хүчнээс улсыг хэрхэн хамгаалах явдалд эвлэлийн гишүүдийг боловсруулах суртлыг нэвтрүүлэхээр...” заажээ. Ийнхүү ард иргэд, хүн амыг агаарын ба хорт зайн (химийн) довтолгооноос хамгаалахад сургах үүрэгтэй олон нийтийн байгууллага анх 1930 онд буй болсон байна.

МУХЯТЭ-ийг 1931 оноос эхлэн албан ёсоор зохион байгуулалтад оруулж, төв, орон нутагт байгуулан үйл ажиллагааг нь явуулах болсон байна. Энэ үед тус эвлэлийг

Улсыг батлан хамгаалах бүлгэм гэж нэрлэж байв. МУХЯТЭ-ийн дүрэмд эвлэлийн гишүүд, ард иргэдийг агаарын довтолгоо, хорт зай (хими)-аас хамгаалахад сургах үүрэг анхлан тусгагдсанаар иргэний хамгаалалтын албаны хүрээнд гүйцэтгэх анхны үйл ажиллагааны эхлэлийг тавьсан гэж үзэж болох юм.

Засгийн газар, МУХЯТЭ болон түүнийг залгамжилсан дараагийн байгууллагуудын хүрээнд авч хэрэгжүүлж байсан зарим арга хэмжээний талаар товч өгүүлье. Эдгээр нь:

- Улсыг батлан хамгаалах комисс 1935 тогтоол гаргаж, байлдааны цагт том аж ахуйн газар, албан яам, ард олныг агаарын дайсан, хорт зайн аюулаас хамгаалахын тулд газарт тусгай орон сав байгуулах, тус улсын батлан хамгаалах явдлыг ард олонд таниулах, Улаанбаатар хот, аймгийн төвүүд зэрэг төв суурин газарт цэргийн сургуулилыг УБХЗ-өөс гаргасан хөтөлбөрийг баримтлан тогтмол явуулахыг яамдын сайд, тусгай газрын дарга нарт хариуцуулж байв.
- БНМАУ-ын Засгийн газрын 1936 оны тавдугаар сарын хуралдаанаар Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн оруулсан саналаар УБХЭ-ийн түр дүрмийг баталжээ. Уг дүрмээр УБХЭ-ийн үүрэг зорилтыг тодорхой болгосны дотор агаарын дайсан, химийн аюулаас хамгаалах үүрэг нь ч тодорхой болон орсон байна.
- Батлан хамгаалах тусгай комиссын 1938 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн анхдугаар хурлын тогтоолоор “Агаарын дайсан, хорт зайнаас хамгаалах ажлыг эрхлэх газар”-ыг байгуулсан. Энэ газрын үүргийг: Орон сууц, олон нийтийн байшин барилгыг хамгаалахад туслах; агаар, хорт зайнаас сэргийлэн хянах; довтолгооны аюулыг урьдаас тогтоосон дохиогоор ард нийтэд сонсгон мэдэгдэх; хордсон газраар нэвтрэх зам гаргах; хамгаалах хэрэгслийг ашиглаж сургах; хордсон, шархадсан хүмүүсийг эмнэлгийн байранд зөөвөрлөн анхны тусламж үзүүлэх явдал гэж тодорхойлсон байв.
- МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1942 оны хоёрдугаар сарын 24-ний өдрийн 19 дүгээр хурлын тогтоолоор Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядыг төв, орон нутагт байгуулж, түүний ажлыг удирдах үүргийг УБХЭ, Дотоод явдлын яаманд даалгажээ. Тус отрядыг дэлхийн II дайны жилүүдэд аймаг, сумдад өргөн олныг хамруулан зохион байгуулж байв. Энэ отряд батлан хамгаалах үйл хэрэгт хөдөлмөрчдийг сургахад туслахын зэрэгцээгээр армийн хүчийг сэлбэх, ард түмнийг агаарын дайралт, химийн хордолтоос хамгаалах арга ажиллагаанд сурган дадлагажуулах үндсэн үүргийг гүйцэтгэж байснаараа тухайн түүхэн нөхцөлд иргэний хамгаалалтын үйлст зохих хувь нэмэр оруулсан бөгөөд өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлж байсан.

БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооны 1949 оны зургаадугаар сарын 4-ний өдрийн 113/25 дугаар тогтоолоор АӨХСДМО-ыг татан буулгаж, түүний

эрхэлж байсан зарим үүргийг Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Биеийн тамир, спортын байгууллагад хариуцуулжээ.

**Хоёр. Хүйтэн дайны нөхцөлд батлан хамгаалах үйл хэрэгт иргэдийн үүрэг
оролцоог өргөжүүлэх талаар хийсэн алхмууд**

Дэлхийн II дайн дууссанаас хойших 10 гаруйхан жилийн хугацаанд олон улсын харилцаанд ихээхэн өөрчлөлт гарч, капиталист, социалист хоёр систем үүсэж, цэрэг-улс төрийн эвслүүдийг байгуулж, атом, химийн болон үй олноор хөнөөх бусад хэрэгсэл цэргийн зэвсэглэлд нэвтэрсний улмаас дэлхийн улс гүрнүүдийн бодлого, үйл ажиллагаанд хүйтэн дайны үе эхэлсэн байна.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1957 оны хоёрдугаар сарын 11-ний өдрийн 57 дугаар тогтоолоор Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг (АЦТСДН)-ийг Биеийн тамир, спортын хороонд байгуулсан байна. Уг тогтоолоор тус нийгэмлэгийн дүрмийг баталж, түүнд “Ардын цэрэгт туслах зорилгоор нийгэмлэгийн гишүүд, нийт хөдөлмөрчдийг цэргийн шинжлэх ухаан, төрөл бүрийн техник, агаарын цэргийн мэдлэг, атом, химийг эсэргүүцэх хамгаалалтад бэлтгэн, биеийн тамир, спортын хэлбэрүүдэд сургахад тусална” гэж үүргийг нь тодорхойлж, дүрмийн 3.в-д “...атом ба химийг эсэргүүцэх бүх төрлийн хамгаалалтад сургах, дугуйлан, курс ... байгуулах” гэж заагаад тэдний ажлыг удирдах үүргийг тус нийгэмлэгт хариуцуулжээ.

Үүнийг дараа дараагийн шийдвэрүүд, үйл ажиллагааг тод харуулдаг юм. Тухайлбал:

- МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1958 оны дөрөвдүгээр сард “Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэгийн тухай” 93 дугаар тогтоол, мөн оны зургаадугаар сард 183 дугаар тогтоол гаргаж, төв суурин газрыг агаарын довтолгооноос хамгаалах арга хэмжээг Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах яамтай хамтран боловсруулах, атом, устөрөгчийн хор хөнөөл, түүний аюулаас хүн ам, албан газрыг хамгаалах аргын тухай сургуулийн программд хичээлийн гадуур оруулах, атом, химийн довтолгооноос урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай хөдөлмөрчдөд тайлбарлан таниулах, сургалт явуулах, албан үйлдвэрийн газрыг хамгаалалттай болгох зэрэг заалтыг АЦТСДН-т өгч, түүнийг хэрэгжүүлэхэд практик туслалцаа үзүүлэхийг Цэргийн яаманд даалгасан байна.
- БНМАУ-ын СнЗ, НТХ-ны Улс төрийн товчооны 322/18 дугаар тогтоолын дагуу Ардын цэргийн хэрэг эрхлэх яам (АЦХЭЯ)-ны сайд бөгөөд Ардын цэргийн командлагч 1960 оны долоодугаар сарын 31-ний өдрийн 00111 тоот тушаалаараа АЦТСДН-ийг татан буулгаж, БХХН болгон өөрчилж, түүнийг тус яамны харьяанд байгуулав.

Тус зөвлөл үндсэн ажлаа иргэдэд орчин үеийн хөнөөлт зэвсгийн учруулах хор хөнөөлийг ойлгуулан түүнээс хамгаалах аргад сургаж дадлагажуулахад чиглүүлж байжээ. Улаанбаатар хот, аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх

Захиргаанд БХХН-ийн штабыг байгуулж, тэдгээр нь орон нутагт хөнөөлт хэрэгслээс хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг гүйцэтгэж байв.

Гол зорилт нь:

- Атом, устөрөгчийн зэвсэг, түүний хор хөнөөлөөс албан газар, хүн амыг хамгаалах тухай болон сургуулиудад программд хичээлээс гадуур мэдлэг олгох;
- Ард иргэдийг агаарын довтолгооноос хамгаалах зорилгоор тэднийг атом, химийн ба бактериологийн зэвсгийн хор хөнөөлийг устгах, тэдгээрийн дайралтад орсон газар зэргийг ариутган цэвэрлэх, нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн туслалцаа үзүүлэх мэдэгдэхүүнтэй болгох талаар хүчтэй ажил зохиох;
- Энэ талаар хөдөлмөрчдийн дунд ухуулга сурталчилгааны ажлыг хүчтэй өрнүүлэх явдал байв.

БХХН-ийн Төв Зөвлөлийн дарга 1963 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн 5 тоот тушаал гаргаж, “Үй олноор устгах зэвсгийн хөнөөл, түүнээс хамгаалах тухай нийт хөдөлмөрчдөд таниулах ажлыг өргөн зохиохын хамт цөмийн ба химийн болон бактериологийн дайралтаас өөрийгөө хамгаалах хэрэгт хөдөлмөрчдийг сургах олон нийтийн зааварлагч нарыг хот суурин газарт 50 хүнд нэг зааварлагч оногдохоор бэлтгэн гаргахыг аймаг, хотын зөвлөлийн штабын дарга нарт үүрэг болгосугай” гэж заасан байна. Дунд сургууль, техникумын тусгай бэлтгэлийн программыг олон нийтийн зааварлагчийн программд ойртуулан боловсруулах, суралцагчдыг нь тийм үүрэг гүйцэтгэж чадахуйцаар бэлтгэх, түүнд зориулж гарын авлага болох материалаар хангах зорилт тавьж байжээ. Дээрх тогтоол, тушаал, гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг дараах баримтууд гэрчилж байна.

- Улаанбаатар хотод 1961 онд ард иргэдийг үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах аргад сургах багш бэлтгэх 5-7 хоногийн түр курсыг зохион байгуулж, хоёр удаагийн сургалтаар 56 хүнийг бэлтгэн гаргасан байна. Зааварлагч нарын курсыг 40 цагийн хөтөлбөрөөр явуулж, 1962 онд 210 хүн, 1963 онд 430 хүнийг бэлтгэжээ. Энэ бол ирээдүйн нийт ард иргэдийн сургалтын тогтолцооны эхлэл байв.
- Аймаг, хотын намын хороо, АДХГЗ-ны дарга, яам, тусгай газрын сайд, дарга, орлогчид, газар, хэлтсийн дарга нартай 1961 оноос 1-3 өдрийн цугларалт, семинар үе үе зохион байгуулж, тэдэнд олон улсын цэрэг, улс төрийн байдал, ҮОХЗ-ийн хор хөнөөл, түүнээс хамгаалах аргын тухай болон тус улсад хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө чиглэл өгдөг байжээ.
- БХХН-ийн Төв Зөвлөл НТХ-ны 1961 оны наймдугаар сарын 24-ний өдөр гаргасан “Улсыг батлан хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай” мн/289 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр “Дайсны болзошгүй элдэв халдлагаас хот, суурин, сум-нэгдэл, албан ба үйлдвэр, аж ахуйн газрыг хамгаалах отряд, хэсгийг зохион байгуулах тухай аргачилсан заавар”-ыг 1961

оны 11 дүгээр сард гарган отряд, хэсгийг төв, орон нутагт зохион байгуулан сургах ажлыг хийж эхэлжээ. Энэ үед сургалтын тодорхой хөтөлбөр, гарын авлага, хэрэглэгдэхүүн байгаагүй, түүнийг удирдах мэргэжилтэн бэлтгэгдээгүй байв. Сургалтын дүн мэдээнд отряд, командын сургалт нь ард иргэдийн нийтлэг сургалттай хамт орж байсан байна. Энэ бол мэргэжлийн ангийн үүсэл, түүний сургалт бэлтгэлийн эхлэл байсан гэж үзэж болох юм.

Ийнхүү БХХН-ийн авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд нь тухайн үед (хүйтэн дайны нөхцөл нэгэнт бий болсон үед) эх оронд учирч болзошгүй аюулыг сөрөн тэсвэрлэхэд ард иргэдийн үүрэг, оролцоог төлөвшүүлэх дараа дараачийн системтэй үйл ажиллагааны тодорхой эхлэл байснаараа түрүү түрүүчийнхээсээ илүү бодитой байсан юм.

Гурав. Монгол Улсын иргэний хамгаалалтын алба үүсэж бэхэжсэн нь (1964-2004)

Хүйтэн дайн 1960-аад оны дунд үе болоход даамжирч, социалист капиталист хоёр ертөнцийн сэргөлдөөн лавшран гүнзгийрсний улмаас олон улсын байдал төвөгтэй болсон, мөн түүнчлэн хоёр хөршийн харилцаанд гүнзгий ан цав үүсэж, манай улсын гадаад орчин нэн таагүй байдалтай болсон. Ийм нөхцөлд МАХН-ын Төв Хороо, Засгийн газар улс орныг батлан хамгаалах, түүний дотор иргэний хамгаалалтын албыг үүсгэн бэхжүүлэх талаар олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Орчин үеийн иргэний хамгаалалтын албыг үүсгэн байгуулж, түүнийг улсын хэмжээний тогтолцоо бүхий алба болгон хөгжүүлэн бэхжүүлэхэд Намын Төв Хороо, Засгийн газраас гаргаж хэрэгжүүлсэн чухал ач холбогдолтой дараах шийдвэрүүд түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр нь:

1. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн 1964 оны хоёрдугаар сарын 29-ний өдөр гаргасан “Батлан хамгаалах ба хөдөлмөр нийгэмлэгийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 8/94 дүгээр тогтоол юм. Уг тогтоолоор БХХН-ийн Төв зөвлөлийн бүтэц, орон тоог шинэчлэн баталж, дарга нь Ардын Цэргийн Хэрэг Эрхлэх Яам (АЦХЭЯ)-ны орлогч сайд байхаар шийдвэрлэжээ. БХХН-ийн Төв зөвлөлийн бүтцэд Атом, химийн хэлтэс, Байлдааны хэлтэс, Олон нийтийн зааварлагч нарыг бэлтгэх байнгын курс гэсэн нэгжүүд байгуулсан нь тухайн үеийн иргэний хамгаалалтын албаны анхны нэгжүүд буюу иргэний хамгаалалтын албыг цаашид зохион байгуулан удирдах байгууллагын эх суурь тавигдсан гэж үздэг юм. Харин Техник спортын хэлтэс нь буудлага, радио, авто, мото, шүхрийн спортыг хөгжүүлэн удирдах нэгж юм. Хэдэн жилийн дараа энэхүү бүтцийн нэгжүүдийн эрхлэх асуудлуудын зааглалаар БХХН нь Улсын иргэний хамгаалалтын газар болон Батлан хамгаалахад туслах нийгэмлэг болж салжээ. Энэ хоёр байгууллага аль аль нь иргэдийг улс орныг батлан хамгаалахад бэлтгэн оролцуулах үүрэгтэй байв.
2. БНМАУ-ын СнЗ-ийн 1964 оны есдүгээр сарын 30-ны өдрийн 435 дугаар

тогтоолоор батлан мөрдүүлсэн, БХХН-ийн дүрмийн гуравдугаар зүйлд иргэний хамгаалалтын талаар гүйцэтгэх үүргийг тодорхойлсон. Үүргийн гол агуулга нь үй олноор сүйтгэх зэвсгээс ард иргэд, улс ардын аж ахуйг хамгаалах хэрэгт бүх ард иргэдийг сургаж бэлтгэх, үйлдвэрийн газрууд, цахилгаан, тээвэр, холбооны байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах бэлтгэл арга хэмжээ авч явуулах, ард иргэд, улс ардын аж ахуйд түгшүүртэй байдлын тухай зарлан мэдээлэх, түгшүүртэй үед ажилчин, албан хаагчдыг тараан байрлуулах, иргэдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах, бактериологи, цацраг идэвхт болон химийн хордолтоос хүн ам, ус, бэлчээр, ургамал, малын тэжээл, түүхий эд, хүнс хэрэглэл, адгуус малыг хамгаалах, түүнчлэн халдварын хор хөнөөлийг устгах талаар арга хэмжээ авах, хор уршгийг устгах, хөнөөлийн голомт дахь хойшлуулшгүй сэргээн босгох, аврах ажил явуулах байлаа.

3. 1965-1969 онд гаргаж хэрэгжүүлсэн тогтоолоос дурдвал:

- БНМАУ-ын СнЗ-ийн 1965 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Дайсны довтолгооны аюулыг зарлах удирдлага, дохиог тогтоох тухай” м/н 515 дугаар тогтоолоор БХХН-ийн байлдааны бэлэн байдлын зэргийг тогтоосон байдаг. Бэлэн байдлын зэргийг: а/Байлдааны өндөржүүлсэн бэлтгэлийн үе, б/Онцгой үе хэмээн тогтоосон байна. Бэлэн байдлын зэргийн төрөл, түүний үндэслэлийг улам боловсронгуй болгон шинэчлэн 2000-аад оны эх хүртэл мөрджээ.
 - БНМАУ-ын СнЗ-ийн 1967 оны долоодугаар сарын 19-ний өдрийн 208 дугаар тогтоолоор улс төр, эдийн засгийн чухал ач холбогдолтой зарим хот, суурин газарт иргэний хамгаалалтын талаар зэрэглэл тогтоосон.
4. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1969 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “БНМАУ-ын Иргэний хамгаалалтыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” мн/32 дугаар тогтоол гарав. Энэ тогтоолд: “Иргэний хамгаалалт нь улсын нийт хүн ам, улс, олон нийт, аж ахуйн бүх байгууллагыг хамарсан бөгөөд батлан хамгаалах ажлын ард нийтийн систем болж байна” гэж дүгнээд Улсын иргэний хамгаалалтын байгууллагыг БХЯ-ны бүтцээс гаргаж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд шууд хариуцуулахаар болов.
5. БНМАУ-ын СнЗ НТХ-ны дээрх тогтоолыг үндэслэж, 1969 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Иргэний хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” мн/403 дугаар тогтоол гаргажээ. Энэ тогтоол иргэний хамгаалалтын бүхий л арга хэмжээг улсын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг нээж өгсөн зарчмын ач холбогдолтой шийдвэр байв. Иргэний хамгаалалтын албыг удирдах төв байгууллагыг биенийг нь даалган СнЗ-ийн харьяа тусгай газар (яам эрхтэй), түүний удирдлагын байгууллага болох Улсын иргэний хамгаалалтын Төв штабыг байгуулахаар шийдвэрлэсэн нь иргэний хамгаалалтын ач холбогдлыг өндөрт өргөж, улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан юм.

6. Олон Улсын байдал нэн төвөгтэй болж, хүйтэн дайн даамжирсан 1970-1980-аад оны үед манай улсын хүн ам, эдийн засаг, улс ардын аж ахуйн салбарыг болзошгүй дайны аюул, ҮОХЗ-ээс хамгаалах арга хэмжээг Батлан хамгаалах нэгдсэн удирдлага, бодлоготой уялдуулах шаардлага гарсан ажээ. НТХ, СнЗ Улсын Иргэний хамгаалалтын газар (УИХГ)-ыг Батлан хамгаалах яамны бүтцэд оруулах шийдвэр гаргажээ. Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр гарсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны нэгдүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар зарлигт “БНМАУ-ын Иргэний хамгаалалтын газрыг 1975 оны хоёрдугаар сарын 1-нээр тасалбар болгон Батлан хамгаалах яаманд нэгтгэсүгэй” гэж зааснаар ийнхүү УИХГ БХЯ-ны харьяанд эргэн ирсэн юм. Бүтцийн энэ тогтолцоо нь иргэний хамгаалалтын байгууллага цэвэр тайван цагийн үүрэг гүйцэтгэж, 2004 хүртэл үргэлжилжээ.

Дөрөв. Иргэний хамгаалалтын эрх зүйн орчны бүрдэлт

БНМАУ-ын Иргэний хамгаалалтын албаны улсын хэмжээний тогтолцоот арга хэмжээнүүд нь эхний жилүүдэд Төв Хороо, Засгийн газрын тогтоолуудын заалтаар зохицуулж байсан байна. Иргэний хамгаалалтын албаны эрхзүйг оновчтой болгох талаар хэд хэдэн хууль, дүрэм зэрэг баримт бичиг батлан мөрдүүлсэн нь уг арга хэмжээг орон даяар зохион явуулах, нийт ард түмнийг үйл ажиллагаанд оролцуулах хууль эрхзүйн үндэс болж мөрдөгдөж байв.

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны наймдугаар сарын 26-ны өдрийн 150 дугаар зарлигаар “БНМАУ-ын Иргэний хамгаалалтын тухай хууль”-ийг батлан мөрдүүлэв. Энэ хуульд БНМАУ-ын иргэний хамгаалалтын тогтолцоо, үндсэн үүрэг (зорилт), иргэдийг татан оролцуулах хэлбэр, төв орон нутгийн ард иргэдийн сургалт зэргийг анх удаа хуульчлан тогтоосон юм.

Хуулийн 1-р зүйлд: “БНМАУ-ын Иргэний хамгаалалт нь дайсны үй олноор хөнөөн сүйтгэх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс хүн ам, улс ардын аж ахуйг хамгаалах, хөнөөлийн голомтод аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажил явуулахын тулд тайван ба дайны үед хэрэгжүүлэх улс нийтийн батлан хамгаалах арга хэмжээний систем мөн” гэж тодорхойлжээ.

Тус хуульд иргэний хамгаалалтын үндсэн зорилт(үүрэг)-ыг:

- Үй олноор сүйтгэх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс хамгаалах арга ажиллагаанд ард иргэдийг нийтээр нь заавал сургах;
- Улс ардын аж ахуйг дайны үед байнга тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээг авч явуулах;
- Хүн амд зарлан мэдээлэх болон иргэний хамгаалалтын бат тогтвортой удирдлагын системийг зохион байгуулах;
- Иргэний хамгаалалтад шаардагдах хүч хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай үед ашиглахад бэлэн байлгах, хөнөөлийн голомтод аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажил зохион байгуулах;

- Дайсны үй олноор хөнөөх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс хүн амыг хамгаалах, дайны үед нэрвэгдсэн хүн амд анхны тусламж үзүүлэх;
- Усны эх булаг, хүнс тэжээл, түүхий эд, мал ургамал, тэжээл, бордоог цацраг идэвхт бодис химийн хордлого, бактериологийн халдварлалаас хамгаалан түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авах явдал гэж заажээ. Ийнхүү хуульд тодорхойлсон иргэний хамгаалалтын томьёолол, зорилт (үүрэг) нь түрүү түрүүчийн Төв Хороо, Засгийн газрын тогтоолуудаар томьёолж байсан тодорхойлолтуудыг системчлэн улам боловсронгуй болгосон юм.

2. БНМАУ-ын СнЗ-ийн 1970 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар “БНМАУ-ын Иргэний хамгаалалтын дүрэм”-ийг баталжээ. Энэ дүрмийг 10 жил мөрдөөд СнЗ-ийн 1980 оны гуравдугаар сарын 21-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан юм. Иргэний хамгаалалтын тухай хууль, Иргэний хамгаалалтын дүрэм батлагдсанаар дайсны үй олноор хөнөөх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс улсын хүн ам, улс ардын аж ахуйн объектыг хамгаалах, хөнөөлийн голомтод аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулах хууль эрхзүйн орчин бүрдэж, иргэний хамгаалалтын байгууллага богино хугацаанд удирдлага, бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн бэхжиж үүрэг зорилт нь өргөжиж, хүн ам, улс, олон нийтийн болон аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний бүх байгууллагыг хамарч орон даяар үйл ажиллагаагаа явуулах болсон байна.

3. ЗХУ-ын удирдагч М.С.Горбачёвын 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхэн үед дэвшүүлсэн өөрчлөн байгуулалтын бодлогын нөлөөгөөр олон улсын харилцаа, түүний дотор өмнөд хөрштэй харилцах бодлого, үйл ажиллагаанд гарсан нааштай өөрчлөлтүүдтэй уялдуулан манай улс батлан хамгаалах салбарт шинэчлэлийг эрэлхийлж байсны нэг хэсэг нь иргэний хамгаалалтын бодлого, үйл ажиллагааныхаа эрхзүйн үндсийг шинэчлэх зорилт тавигдах болов. Ингээд БНМАУ-ын СнЗ-ийн 1990 оны тавдугаар сарын 25-ны өдрийн 276 дугаар тогтоолоор байгалийн гамшиг, үйлдвэрийн томоохон осол, хүн ба мал амьтны гоц халдварт өвчин, цацраг идэвхт хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын аюул, нөлөөнөөс хүн ам, улс ардын аж ахуй, байгаль орчныг урьдчилан сэргийлж хамгаалах, хор хөнөөлийг арилгах ажлыг зохион байгуулах үүрэгтэй Улсын байнгын онцгой комисс /УБОК/-ыг СнЗ-ийн дэргэд байгуулж, бүрэлдэхүүн, дүрмийг батлан мөрдүүлсэн байна. Мөн аймаг, хотын Байнгын онцгой комисс (БОК)-ыг байгуулж, дарга нь аймаг, хотын АДХГЗ-ны дарга байхаар шийдвэрлэжээ. Нийгмийн шилжилтийн үед иргэний хамгаалалтын шинэ зорилт, үйл ажиллагааг эрхлэн явуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байсан 1990-ээд оны эхний жилүүдэд иргэний хамгаалалтын арга хэмжээг Засгийн газрын тогтоол, шийдвэр гарган хэрэгжүүлж байсан.

4. Улсын Их Хурал 1994 оны тавдугаар сард “Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай” шинэ хуулийг батлан гаргав. Энэ хуулиар “Иргэний хамгаалалт нь хөнөөх хэрэгслийн хөнөөл, гамшиг, ослын аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, учирсан хор уршгийг арилгах,

эдгээр арга ажиллагаанд иргэдийг сургаж бэлтгэх цогцолбор арга хэмжээ мөн” гэж тодорхойлжээ. Иргэний хамгаалалт нь дайны болон тайван цагт дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, эд хөрөнгийг хамгаалах, хөнөөлийн голомтод аврах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажил зохион байгуулах;
- Мал, тэжээвэр амьтан, таримал ургамал, хүнс, тэжээл, усны эх булаг, эд хөрөнгийг цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, бактериологийн халдвараас хамгаалах, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авах;
- Хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулын тухай хүн амд зарлан мэдээлэх, иргэний хамгаалалтын холбоо, зарлан мэдээлэл, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийн бэлэн байдлыг хангах;
- Хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулаас хамгаалах арга ажиллагаанд иргэдийг сургаж бэлтгэх;
- Аврах, хамгаалах ажилд шаардагдах хүч хэрэгслийг зохион байгуулж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, материал, техник, багаж бусад хэрэгслийн нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх;
- Гамшиг, ослоос үүссэн хөнөөлийн голомтод аврах ажлыг зохион байгуулах гэжээ.

Ийнхүү иргэний хамгаалалтын албыг үй олноор хөнөөх зэвсэг хэрэглэсэн дайн гарч болзошгүй гэсэн хүйтэн дайны үеийн үзэл баримтлалаар зохион явуулах бодлогоос татгалзаж, тайван цагийн үүрэгт шилжүүлэх эрхзүйн шинэ орчин бий болов. Тус хуульд анх удаа Монгол Улсын Ерөнхий сайд Улсын иргэний хамгаалалтын дарга байхаар зааж өгсөн нь иргэний хамгаалалтын арга хэмжээг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар хэрэгжүүлдэг, салбар дундын чанартай байдаг онцлогийг харгалзан үзэж, дээд удирдлагыг нь Засгийн газрын тэргүүний хэмжээнд гаргаснаараа урьд өмнө байгаагүй онцгой шийдэл байсан юм.

5. Монгол орны хэмжээнд байгалийн аюулт үзэгдэл, гамшиг, хүн, малын гоц халдварт өвчний гаралтын тоо, хамрах хүрээ, хохирлын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байсан болон тэдгээртэй тэмцэх үйл ажиллагааг олон улсын байгууллагуудтай уялдуулан зохицуулж, хамтран ажиллахад Иргэний хамгаалалтын тухай хуулийн үзэл баримтлал, агуулга хүчин мөхөсөх болов. Ийм учраас тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигджээ. Ингээд уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж УИХ-д оруулсан байна. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх явцад тус хуулийн анхны нэр өөрчлөгдөж, “Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль” нэртэйгээр УИХ-ын 2003 оны зургаадугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар батлагдсан байна.

Тав. Иргэний хамгаалалтын үйл ажиллагаа дахь иргэдийн оролцооны хэлбэр ба түүний хэрэгжилт

Иргэний хамгаалалтын эрх зүйн баримт бичгүүдэд иргэний хамгаалалтын үүргийг хэрэгжүүлэхэд нийт иргэдийг хамруулан оролцуулах заалтуудыг тодорхой тусгаж ирсэн байдаг. Иргэдийн оролцооны гол хэлбэр нь бүх нийтийн сургалт болон ухуулга, сурталчилгааны арга хэмжээнүүд байв.

Хүн амыг 1970-1990-ээд оны эхэнд долоо ангилж, тус бүрийг гүйцэтгэх үүрэгт нь тохирсон хөтөлбөрөөр сургалтыг явуулж байв. Энэхүү ангилал 1970-аад оны эхнээс цэгцэрч төлөвшин, хэвшсэн байна. Сургалтын ангилал нь удирдах бүрэлдэхүүний, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний, ажилчин, албан хаагчдын, оюутан, сурагчдын, ард иргэдийн, малчдын, тариаланчдын, гэрийн ажилтай иргэдийн гэж байв. Сургалтыг Улсын иргэний хамгаалалтын Төв штаб тус тусынх нь хөтөлбөрийн дагуу удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байжээ. Бүх нийтийн ухуулга сурталчилгааны ажил иргэний хамгаалалтын албаны нэг чухал хэсэг байсан байна.

Ухуулга, сурталчилгааны ажлын зорилго нь олон улсын цэрэг-улс төрийн байдал, тэр нь манай улсад хэрхэн нөлөөлж байгаа, цаашид яаж нөлөөлж болох, нам, төр, засгаас баримталж байгаа бодлогын агуулга, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, иргэний хамгаалалтын үүрэг зорилт, олон талт ажлыг зохиох шаардлага, хэрэгцээ, иргэдийн гүйцэтгэх үүрэг, оролцоо, ач холбогдол зэргийг тайлбарлан таниулах явдал байсан байна.

Мэдээллийн өргөн хэрэгсэл байхгүй, хүн амын боловсрол, мэдлэг тун нимгэн байсан он жилүүдэд үүсэж болзошгүй нөхцөл байдал, ард иргэдийн гүйцэтгэх үүргийг нь тэдэнд ойлгуулах явдал нэн төвөгтэй зорилт байсан байна. Энэ үед байгууллага, хамт олны дунд аман яриа, таниулга хийх, албан байгууллага, сум, дүүрэг, аймгийн төвд зохион байгуулалттайгаар иргэдийг цуглуулж нэгдсэн лекц унших, орон нутгийн болон төвийн сонин хэвлэлээр дамжуулан сурталчлах, төвийн ба орон нутгийн радио, телевизээр сэдэвчилсэн нэвтрүүлэг явуулах, сургалт, сурталчилгааны кино, диафильм үзүүлэх зэрэг арга хэлбэрүүдийг нийтлэг ашиглаж ирсэн.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн 1965 оны дөрөвүгээр сарын 9-ний өдрийн 101/119 дүгээр тогтоолд тодорхой заалтууд орсноос хойш суртал ухуулгын ажлын далайц улам өсөж, төрөл хэлбэр нь нэмэгдсэн байна. Уг тогтоолд “Улс орныг батлан хамгаалах ба ардын армийн дайчин замналыг сурталчлах” сарын ажлыг жил бүрийн хоёрдугаар сарын 15-аас гуравдугаар сарын 15 хүртэл улс орон даяар зохион явуулж байх заалтыг холбогдох байгууллагуудад даалгасан нь цаашдаа иргэний хамгаалалтын ухуулга, сурталчилгаанд чухал ач тустай болсон юм. Энэ сарын ажлыг 1970, 1980-аад онд “Батлан хамгаалах зорилтыг сурталчлах сарын ажил” нэртэйгээр өргөн агуулгатайгаар явуулдаг болж, түүний бүрэлдэхүүнд иргэний хамгаалалтын ухуулга, сурталчилгааны ажил тодорхой байр суурьтай байв.

Ухуулга сурталчилгааны ажлыг Улсын иргэний хамгаалалтын Төв штаб зангидаж удирдаж, аймаг, хот, дүүргийн иргэний хамгаалалтын штабууд орон нутагтаа зохион байгуулж явуулдаг байжээ.

Төгсгөл

Иргэний хамгаалалт нь аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөл, гамшиг, ослоос хамгаалахад иргэдийн эрхэлдэг ажил алба буюу нийгэмд эзэлж буй байр суурь, боловсрол, нас, хүйс, хаана оршин суудаг зэргийг үл харгалзан бүх нийтийг оролцуулдаг (оролцоог нь хангадаг) онцгой алба байсан, одоо ч байсаар байна, цаашдаа ч байх нь ойлгомжтой юм.

Түрүү үеийн Иргэний хамгаалалтын тухай хуулийг шинэчлэн найруулж, боловсруулсан хуулийн төслийг УИХ-аар 2003 онд хэлэлцэх явцад хууль тогтоогчид түүний мөн чанар, агуулгыг үл харгалзан зөвхөн нэрийг нь “Гамшгаас хамгаалах тухай” гэж өөрчилснөөр энэ хууль төрсөн түүхтэй байдаг. Уг хуулийн агуулга нь түрүү үеийн Иргэний хамгаалалтын тухай хуулиар тогтоон мөрдөж байсан “тайван цагийн үүрэг”-ийг бие даалган тусгай хууль болгосонд оршиж байгаа юм. Тиймээс 2003 оны Гамшгаас хамгаалах тухай хуульд нийцүүлэн байгуулсан орчин цагийн Онцгой байдлын алба нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, алба хаагчдын эрх зүйн байдал зэрэг олон талаараа түрүү үеийн иргэний хамгаалалтын албатай үндсэндээ ижил байгаа.

Онцгой байдлын алба иргэний хамгаалалтын албаны тайван цагийн үүргийг дээрх хуулийн хүрээнд шууд залгамжлан хэрэгжүүлж байгаа болон Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, гадаадын зарим орны ижил төстэй байгууллагын туршлага, мөн түүнчлэн олон улсын өнөөгийн байдлыг харгалзан тус албыг “Иргэний хамгаалалтын алба” болгон өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр зохиож байгаа ажлын агуулга, үзэл санаа нь иргэдийн оюун санаа, сэтгэл, итгэл үнэмшилд ойр дөт тусаж, үр өгөөж нь өсөх ач холбогдолтой юм. Нэрний энэ өөрчлөлт нь тус албаны тогтолцооны харьяалалд үл хамаарна. Үүний тулд Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулах болно.

Civil Defence and National Resilience

Damdin Purev

Doctor (Ph.D), Associate professor, pdamdin43@gmail.com

Ulaanbaatar, Mongolia

Received: September 15, 2025 | Accepted: September 22, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>